

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 25 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2025-01

Улаанбаатар хот

2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтын дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") 2024 оны үйл ажиллагааны тайлан ("2024 оны үйл ажиллагааны тайлан")-г хянан хэлэлцээд 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2025-09 тоот тогтоол гарган, 2024 оны үйл ажиллагааны тайлан нь Банкны үйл ажиллагааны үр дүнг бодитоор ил тод илэрхийлсэн гэж дүгнэж ("ТУЗ-ийн дүгнэлт"), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
- Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчид хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Банкны 2024 оны үйл ажиллагааны тайланг энэхүү тогтоолын хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 25 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2025-02

Улаанбаатар хот

2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн
талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-ийн зөрчилгүй гэж нягтлан баталгаажуулсан Банкны 2024 оны санхүүгийн тайлан ("2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан")-г Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") хянан хэлэлцээд, тус тайлан нь Банкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу бодитоор, ил тод тайлагнасан гэж 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн R-2025-17 дугаар тогтоолоороо дүгнэн ("ТУЗ-ийн дүгнэлт"), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
- Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчид хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Банкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг энэхүү тогтоолын хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 25 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2025-03

Улаанбаатар хот

Банкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас
ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК (“Банк”)–ийн Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Ногдол ашиг хуваарилах эсэх нь Банкны Дүрэмд заасан стратегийн асуудал тул Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал эцэслэн батлах шаардлагатай болохыг;
2. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан, Банкны 2024 оны цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах (“Жилийн эцсийн ногдол ашиг”)–ыг 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн R-2025-03 дугаар тогтоолоороо Хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг;
3. ТУЗ нь 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн R-2025-17 дугаар тогтоолоор 2024 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг баталсан бөгөөд тус тайлан аливаа материаллаг өөрчлөлтгүйгээр батлагдсан болохыг; мөн
4. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс зөвлөмж болгосны дагуу Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, Банкны Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг үндэслэн дор дурдсан дүнгээр Жилийн эцсийн ногдол ашгийг зарлан хуваарилахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Ногдол ашигт нэгж хувьцаанд 27.00 (хорин долоо) төгрөг зарлан хуваарилсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийг Жилийн эцсийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл энэхүү шийдвэр батлагдсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногоос хэтрүүлэлгүйгээр Жилийн эцсийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Хувьцаа эзэмшигч нь банкны дансаараа

дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ



20 25 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2025-04

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК (“Банк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Санхүүгийн Зохицуулах Хороо (“СЗХ”) нь Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг хянан баталгаажуулахдаа Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5 болон 81.6 дахь хэсэгт тус тус заасныг үндэслэн нэр дэвшүүлэх чиг үүргийг цалин урамшууллын чиг үүргээс тусгаарлах зөвлөмжийг ирүүлсэн болохыг;
- Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог: (а) ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, залгамж халааг төлөвлөн зохион байгуулах чиг үүрэг бүхий Нэр дэвшүүлэх хороо болон (б) компанийн засаглалын бодлого журам, ТУЗ-ийн бүтэц, цалин хөлсний бодлого, урамшууллын бүтцийг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Засаглал, цалин урамшууллын хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулах асуудлыг тусгаж Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг R-2025-08 тоот тогтоолоороо зөвлөмж болгосныг; мөн
- ТУЗ-өөс зөвлөмж болгосны дагуу, Хувьцаа эзэмшигчид Банкны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Дээр дурдсаныг үндэслэн, Банкны Дүрмийн дараах хэсгүүдэд доорх нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
8.14. ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад	8.14. ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос Нэр дэвшүүлэх хорооноос тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад

дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.	дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.
8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.	8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.
8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.	8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын, болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын <u>хөрөөн Нэр дэвшүүлэх болон Засаглал, цалин урамшууллын хорооны</u> гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.	8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, Нэр дэвшүүлэх болон <u>Засаглал</u> , цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.

2. Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанк болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт Банкны нэрийн өмнөөс холбогдох аливаа баримт бичгийн хамт хүргүүлж, бүртгүүлэхийг Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 25 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2025-05

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт оруулах тухай

ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банк нь Ахмад настны тухай хууль (2017)-ийн дагуу Банкнаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настанд дэмжлэг, тусламж үзүүлэх зорилгоор байгуулсан Ахмадын сантай болохыг;
2. Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр компаниудад өөрийн дүрэмдээ Ахмадын сан байгуулах болон түүнд компанийн цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувь (3%)-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх асуудлыг тус тус тусгайлан тусгахыг үүрэг болгосныг; мөн
3. Хувьцаа эзэмшигчид нь Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн R-2025-11 тоот тогтоолоор зөвлөмж болгосны дагуу, Банкны Дүрэмд Ахмадын сангийн зохицуулалтыг тусгах, хууль тогтоомжийн өөрчлөлтөд нийцүүлэх зорилгоор нэмэлт оруулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Дээрхийг үндэслэн, Банкны Дүрэмд дараах агуулга бүхий 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг нэмсүгэй:

Нэмэх заалт

5.5. Банк нь Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан Ахмадын сантай байх ба санг Банкны ахмадын тооноос хамааран Банкны цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр бүрдүүлнэ.

2. Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт дээр дурдсан Дүрмийн нэмэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанк болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт Банкны нэрийн өмнөөс холбогдох аливаа баримт бичгийн хамт хүргүүлж, бүртгүүлэхийг даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 25 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2025-06

Улаанбаатар хот

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК болон ХасБанк ХК-ийн хооронд байгуулсан
Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК ("ТСН") болон ХасБанк ХК ("ХасБанк")-ийн хооронд 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан Нэгтгэх гэрээний 8 дугаар зүйлийн 8.6(b) дахь заалтад үндэслэн, ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. ХасБанк болон түүний нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг нь эзэмшдэг толгой компани болох ТСН нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу аль нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээ нь банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангасан байх шаардлагатай болохыг ("**Хуулийн шаардлага**");
2. ХасБанкны хувьцаа эзэмшигчид SR-2024-09 тоот тогтоол гаргаж, энэхүү Хуулийн шаардлагыг хангахдаа ХасБанкийг (i) Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банктай Фреймворк гэрээ болон (ii) Олон Улсын Санхүүгийн Корпорацийтай Бодлогын гэрээг тус тус Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулсан нөхцөлд ТСН-ийг ХасБанкинд нэгтгэж, Нэгтгэх гэрээг байгуулахаар шийдвэрлэсэн ("**Нэгтгэх урьдчилсан нөхцөл**"), нэгдлийн үр дүнд ХасБанк үлдэх ба ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болох нь зүйтэй гэж үзсэн болохыг ("**Нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах**");
3. ХасБанкны хувьцаа эзэмшигчид нь SR-2024-07 болон SR-2024-08 тоот тогтоолоор Нэгтгэх урьдчилсан нөхцөлийг биелүүлэхээр шийдвэрлэсэн болохыг;
4. Нэгтгэх урьдчилсан нөхцөл хангагдаж, ТСН болон ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсний дараа 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр ТСН болон ХасБанкны хооронд Нэгтгэх гэрээг байгуулж холбогдох зөвшөөрөл авахаар Монголбанкинд хүргүүлсэн болохыг;
5. Монголбанкнаас нэгтгэх өөрчлөн байгуулалтын хүсэлтийг хянах явцад ТСН-ийн нийт гаргасан хувьцааны 20.39%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч болох МАК Инвест Кэй Эф Ти-д бий болсон өөрчлөлт нь түүний хувьцаа эзэмшигчдийн бүтцэд Банкны тухай хуулийн шаардлагад нийцүүлэн өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгцээг бий болгосон ба МАК Инвест Кэй Эф Ти нь ТСН дэх өөрийн эзэмшлийн хувьцааг шинээр үүсгэн байгуулагдсан, нэг эцсийн өмчлөгч хасагдсанаас бусдаар эцсийн өмчлөгчийн бүтэц ижил төсөөтэй бие даасан компани болох МАК Инвест Эс Жи Пи Ти И Эл Ти Ди ("**МАК Инвест Эс Жи**")-д шилжүүлэх замаар Банкны тухай хуулийн шаардлагад нийцүүлэхээр шийдвэрлэсэн болохыг ("**ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн бүтцийн өөрчлөлт**");

6. ТСН-ийн Хувьцаа эзэмшигчид нь ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн бүтцийн өөрчлөлтөд холбогдуулан, ТСН-ийн саналын эрх бүхий хувьцааны 20.39%-ийг эзэмших шууд хувьцаа эзэмшигчээр МАК Инвест Эс Жи-г хүлээн зөвшөөрөхөөр SGR-2025-01 тоот тогтоолоор баталсан болохыг; мөн
7. ХасБанк болон ТСН-ийн хооронд байгуулсан Нэгтгэх гэрээнд ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн бүтцийн өөрчлөлтийг тусгаж нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагыг харгалзан, Хувьцаа эзэмшигчид нь Төлөөлөн удирдах зөвлөлийн R-2025-10 тоот тогтоолоор зөвлөмж болгосны дагуу Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. ТСН болон ХасБанкны хооронд байгуулах Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг 1 дүгээр хавсралтад хавсаргасан байдлаар баталсугай.
2. Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээтэй холбогдуулан, Нэгтгэх өөрчлөн байгуулалтад шаардагдах баримт бичгийн хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэх зорилготой “Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах нөхцөл, журам”-д оруулах өөрчлөлтийг 2 дугаар хавсралтад хавсаргасан байдлаар баталсугай.
3. Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг 1 дүгээр хавсралтын дагуу шаардлагатай бусад холбогдох баримт бичгийн хамт ХасБанкны нэрийн өмнөөс үйлдэх эрхийг ХасБанкны Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав (“Эрх бүхий этгээд”)-д олгож, тийнхүү үйлдэхийг даалгасугай.
4. Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг үйлдсэний дараа энэхүү гэрээ болон түүнд холбогдох бүхий л баримт бичгийг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон бусад эрх бүхий байгууллагад холбогдох хууль, тогтоомжийн дагуу ХасБанкны нэрийн өмнөөс хүргүүлж, бүртгүүлэхийг Өөрчлөн байгуулах комиссын гишүүдэд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 25 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2025-07

Улаанбаатар хот

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 8.6(v) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2025-07 дугаар тогтоолоороо ТУЗ-ийн 2025 оны төсөв ("ТУЗ-ийн 2025 оны төсөв")-ийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг дурдав.

ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн 2025 оны төсвийг энэхүү тогтоолын хавсралт ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА